

# Багахангай дүүрэг "Хүн ам зүй, шилжилт хөдөлгөөн ба хэрэгцээ шаардлага" Түргэвчилсэн судалгаа

2022 оны 7-р сар



© З.Эрдэнэ



# Агуулга

Удиртгал ба аргачлал .....	1
Мэдээллийн дүн шинжилгээ.....	2
1.1 Хүн амын суурь тоон үзүүлэлт ба хүн ам зүйн тойм.....	2
1.2 Ирсэн иргэд.....	3
1.3 Явсан иргэд.....	3
1.4 Хөдөлмөр эрхлэлт.....	4
1.5 Санхүүгийн нөхцөл байдал.....	5
1.6 Тулгамдаж буй асуудал, аюулгүй байдал.....	6
1.7 Үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц.....	10
1.8 Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж.....	14
1.9 Тээвэр, замын хөдөлгөөний нөхцөл байдал.....	15
1.10 Хүүхэд болон боловсрол.....	16

# Удиртгал ба аргачлал

## Удиртгал

Дүүргийн түвшний энэхүү тайланд 2022 оны 3-р сард Улаанбаатар хотын хэмжээнд хүн ам, шилжилт хөдөлгөөн, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох шуурхай үнэлгээнд тусгагдсан үндсэн болоод сэдэвчилсэн бүх чиглэлийн тойм мэдээллийг багтаасан болно.

Энэхүү тайлан нь Багахангай дүүргийн хэмжээнд найман үндсэн сэдвийг хамарсан судалгааг багтаасан; тухайлбал, хүн амын суурь тоон үзүүлэлт, хүн ам зүй, ирсэн болон явсан иргэд (шилжилт хөдөлгөөн), хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд ба аюулгүй байдал, үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, хүүхэд болон боловсрол гэх мэт. Мэдээллийг дүүргийн нутаг дэвсгэр, хүний нөөц, засаг захиргааны нэгжийн харилцааны талаарх мэдлэг өндөртэй мэдээлэл нэгтгэгчид болох хэсгийн ахлагч нартай ярилцлага хийх замаар олж авсан.

Энэхүү судалгааны үндэслэл, хэрэгцээ шаардлагын талаар дэлгэрэнгүй мэдээллийг Улаанбаатар хотын дэлгэрэнгүй тайлангаас авч үзнэ үү.

## Аргачлал

Энэхүү тайланд ОУШХБ-ын Шилжих хөдөлгөөнийг тандах матриц (ДТМ)-ийн нэгжээс боловсруулсан хөдөлгөөнийг тандах (МТ) аргачлалыг ашигласан болно.

Судалгаанд хөдөлгөөнийг тандах (МТ) аргачлалыг ашигласан Улаанбаатар хотын хамгийн жижиг засаг захиргааны нэгж болох хэсгийн түвшинд хэсгийн ахлагч нараас мэдээллийг цуглуулав. Хэсгийн ахлагч нар иргэдтэй ярилцах, ажиглалт хийх болон өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан, харилцаа холбооны хэрэгслүүдийг ашиглан тоон мэдээллийг нягтлах, баталгаажуулах ажлыг хийхээр төлөвлөсөн юм. Хэсгийн ахлагч нарыг хүн амын суурь тоон үзүүлэлт, шилжин ирэгсэд ба явагсад, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, аюулгүй байдал, үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц, ногоон байгууламж, хүүхэд ба боловсрол гэсэн найман үндсэн сэдвийг багтаасан судалгааны асуулгыг бөглөхийг хүссэн юм.

Хэсгийн ахлагч нар Кобо программ хамгамжаар дамжуулан тоон мэдээллийг гар утас эсвэл таблет, компьютер ашиглан бөглөж илгээсэн. Хэсгийн ахлагч нарыг ДТМ судалгааны аргачлал, судалгааны асуулга, түүнийг нөхөхтэй холбоотой танхимын сургалтад бүрэн хамруулсан. Түүнчлэн ДТМ-ийн баг мэдээлэл цуглуулах явцад үүссэн аливаа асуулт, асуудалд цаг тухайд нь хариу өгч бэлэн байдалд ажилласан юм.


Өгөгдөл оруулах үйл явц албан ёсоор хаагдмагц ДТМ-ийн баг бүрэлдэхүүн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажлыг эхлүүлсэн бөгөөд өгөгдөл оруулахад гарч болзошгүй алдаа, тоон мэдээллийн зөрүү, давхардал зэргийг илрүүлэхийн тулд өгөгдлийн хяналтын шатанд чанарын баталгаажуулалтын шалгалтыг хийсэн. Өгөгдөлтэй холбоотой аливаа асуудал илэрсэн тохиолдолд ДТМ-ийн баг тодруулга авахаар хэсгийн ахлагч нартай утсаар холбогдож тоон мэдээллийг тодруулж, баталгаажуулсан байна. Бүх хяналт, шалгалтыг хийж дууссаны дараа мэдээлэлд дүн шинжилгээ хийх үе шатанд шилжсэн. Бүх судалгааны үр дүнг хэсгийн түвшинд дүн шинжилгээ хийж, дараа нь дүүргийн болон хотын хэмжээнд нэгтгэн дүгнэв. Иймээс дүүрэг, хотын түвшинд энэхүү тайланд тусгагдсан аливаа үр дүнг хэсгийн түвшинд ч авах боломжтой гэдгийг дурдах нь зүйтэй юм.

Хязгаарлагдмал байдал, судалгааны аргачлалын талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг Улаанбаатар хотын хэмжээний нэгдсэн тайлангаас үзнэ үү.




# 1. Мэдээллийн дүн шинжилгээ-Багахангай дүүрэг

## 1.1 Хүн амын суурь тоон үзүүлэлт ба хүн ам зүйн тойм



Хүн ам зүй (эзлэх хувь)




Үнэлгээ хийх үед (2022 оны 3-р сар) Багахангай дүүрэгт 4,576 иргэн буюу 1,377 өрх бүртгэгдсэн байна. Үүнээс 50 хувь нь эрэгтэй, 50 хувь нь эмэгтэй байв. Хүн амын 33 хувь нь хүүхэд гэж бүртгэгдсэнээс: 12 хувь нь 0-5 нас, 22 хувь нь 6-17 насны хүүхдүүд байна. Хүн амын 61 хувийг 18-65 насны насанд хүрэгчид, 5 хувийг өндөр настан (65 болон түүнээс дээш насныхан) эзэлж байна.

Нийтдээ 86 хүн архаг, эсвэл хүнд өвчтэй (хүн амын 1.9%), 86 жирэмсэн эмэгтэй (эмэгтэйчүүдийн 3.8%) судалгаа хийх явцад байна гэж бүртгэгджээ. Энэ нь Улаанбаатар хотын хэмжээнд бүртгэгдсэн хамгийн өндөр жирэмслэлт бүртгэгдсэн дүүрэг байв (дүүргийн хүн амд харьцуулахад).

Багахангай дүүрэг тус бүр гурван хэсгээс бүрдсэн 2 хороотой. Хүн амын 57 хувь нь 1-р хороонд, 43 хувь нь 2-р хороонд амьдардаг гэж бүртгэгджээ.


Хүн ам зүйн тойм хүйсээр, хороогоор (эзлэх хувь)



## 1.2 Ирсэн иргэд<sup>2</sup>

2021 онд Багахангай дүүрэгт нийт 120 өрх буюу 228 иргэн ирсэн байна. 2021 онд Улаанбаатар хотын хэмжээнд нийт ирсэн иргэдийн дөнгөж 0.2 хувь нь Багахангай дүүрэгт ирсэн бөгөөд 85 хувь нь 1-р хороонд, 15 хувь нь 2-р хороонд тус тус бүртгэгдсэн байна. Энэ дүүрэгт ирсэн гол шалтгаан нь гэр бүлийн шалтгаан (85%), боловсрол (25%), мал аж ахуй (6%), эдийн засгийн шалтгаан (6%) байна.


Ирсэн иргэд хамгийн их бүртгэгдсэн хороо (ирсэн иргэдийн эзлэх)




## 1.3 Явсан иргэд

2021 онд Багахангай дүүргээс нийт 54 өрх, 102 иргэн явсан байна. 2021 онд Улаанбаатар хотын хэмжээнд нийт Багахангай дүүргээс 0.1 хувь нь явсан гэж бүртгэгдсэн бөгөөд хамгийн өндөр хувь нь 1-р хорооноос (82%) явсан байна. Ерөнхийдөө энэ дүүргээс нүүх болсон гол шалтгаан нь гэр бүлийн шалтгаан (80%) гэж мэдээлжээ.

Явсан иргэд хамгийн их бүртгэгдсэн хороо (явсан иргэдийн эзлэх)



Ирсэн, явсан үндсэн шалтгаанууд (эзлэх хувь)




<sup>2</sup> Ирсэн иргэд гэдэг нь Улаанбаатар хотын дотор эсвэл хотын гаднаас ирсэн эсэхээс үл хамааран Улаанбаатар хотын аль нэг байршилд оршин суухаар ирсэн иргэн, айл өрхийг хэлнэ. Явсан иргэд гэдэг нь Улаанбаатар хотын аль нэг байршлаас явсан эсэхийг үл хамааран явсан иргэн, айл өрхийг хэлнэ.




## 1.4 Хөдөлмөр эрхлэлт

Багахангай дүүргийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбар нь өрхийн хөдөлмөр эрхлэлт (гэрийн ажил), төрийн байгуулга, батлан хамгаалах нь нийт дүүргийн хэмжээнд 33.3 хувийг эзэлж байна. Дүүргийн хүн амын 57 хувийг эзэлдэг 1-р хорооны үндсэн хөдөлмөр эрхлэлтийн салбар нь төрийн байгуулга, батлан хамгаалах салбар (66.6%). Харин 2-р хорооны (хүн амын үлдсэн 43 хувийг эзэлдэг) үндсэн хөдөлмөр эрхлэлтийн салбар нь өрхийн хөдөлмөр эрхлэлт (гэрийн ажил) байв. Багахангай дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн гол салбарууд нь Улаанбаатар хотын дундажаас ихээхэн ялгаатай байв. Улаанбаатар хотын нэгдсэн мэдээлэлд төрийн алба, батлан хамгаалах салбарт хөдөлмөр эрхлэлт зонхилж буй байдал дөнгөж 6 хувь, өрхийн хөдөлмөр эрхлэлт (гэрийн ажил) нь 4хувийг эзэлж байна гэж бүртгэгджээ. Нийслэлийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн зонхилох салбар болох бөөний болон жижиглэнгийн худалдаа нь Багахангай дүүргийн аль ч хэсэгт бүртгэгдээгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбар (хэсгийн эзлэх хувь)



Хөдөлмөр эрхлээгүй хүн ам (18-64 насны иргэдийн эзлэх хувь)



Хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь, хороогоор (18-64 насны иргэдийн эзлэх хувь)


Хороо #1

25%

Хороо #2

52%

Хөдөлмөр эрхлэлтийн төрөл (хэсгийн эзлэх хувь)



Хөдөлмөр эрхлэлтийн төрөл, хороогоор (хэсгийн эзлэх хувь)

Хороо #1	Хороо #2
71% Төрийн байгууллага	66% Төрийн байгууллага

Багахангай дүүргийн хэмжээнд 18-64 насны 1,014 иргэн хөдөлмөр эрхлээгүй байгаа нь насанд хүрсэн хүн амын 36 хувийг эзэлж байна. Тус дүүрэгт хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь Улаанбаатар хотын хэмжээнд хоёрдугаарт орсон бөгөөд улсын дундажаас (30%) зургаан оноогоор илүү байна. Хөдөлмөрийн насны хүн амын 52 хувь нь (617 хүн) хөдөлмөр эрхлээгүй, 2-р хороонд бүртгэгдсэн хөдөлмөр эрхлээгүй хүн амын түвшин өндөр байсан бөгөөд 1-р хороонд 25 хувь, (397 хүн) хөдөлмөр эрхлээгүй гэж бүртгэгдсэн байна.

Багахангай дүүргийн хэмжээнд хувийн хэвшилд хөдөлмөр эрхлэлт ердөө гуравны нэг хувийг эзэлдэг гэж бүртгэгдсэн бол үлдсэн хоёр хувьд нь төрийн албанд хөдөлмөр эрхэлж байна гэж мэдээлжээ. Энэ нь нийслэлийн хэмжээний дундаж үзүүлэлтээс ихээхэн ялгаатай бөгөөд тус дүүргийн иргэдийн гуравны хоёр гаруй хувь нь хувийн хэвшилд ажиллаж дийлэнх нь энэ салбарт ажлын байраар хангагдаж байна. Иргэдийн дөнгөж 15 хувь нь төрийн албанд голчлон ажилладаг гэж мэдээлсэн байна. Багахангай дүүрэгт хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь хавьгүй өндөр байгаа нь хувийн хэвшилд хөдөлмөр эрхлэх боломж бололцоо хомс байгаатай холбоотой байх магадлалтай юм.


## 1.5 Санхүүгийн нөхцөл байдал

Энэ хэсэгт орлогын бууралт болон хүнсэнд зарцуулах зардлын бууралттай холбоотой асуудлаар мэдээлэл нэгтгэгчдийн ажиглалтыг авч үзэх замаар төлбөрийн чадварыг судалсан болно.

Багахангай дүүргийн нийт хэсгийн 17 хувьд нь мэдээлэгчид мэдээлэл цуглуулахаас дөрвөн долоо хоногийн хугацаанд айл өрхүүдэд хоол хүнсний хангамж хангалтгүй байна гэж санаа зовнисон нийт 873 хүн байгааг мэдээлжээ. Энэ нь нийслэлийн бусад дүүргүүдээс ирүүлсэн мэдээлэлтэй харьцуулахад хамгийн бага хувь байв. 1-р хороо хамгийн их өртсөн бөгөөд Багахангай дүүргийн хэсгийн мэдээлэгчид 33 хувь нь хоол хүнсний хомсдолтой байгаа талаар санаа зовж байгаагаа мэдээлсэн. Харин 2-р хорооны нэг ч хэсэгт ийм санаа зовних асуудал байгаагүй байна.

Хэсгүүдийн 17 хувьд нь мэдээлэл нэгтгэгчид мэдээлэл цуглуулахаас дөрвөн долоо хоногийн өмнө айл өрхүүд хүнсний хэрэглээгээ багасгасан тухай сонссон гэж мэдээлсэн нь нийт 873 хүн амыг хамарсан байна. 1-р хорооны хэсгүүдийн 33 хувь нь энэ төрлийн хүнсний хүртээмжтэй байдлын талаар мэдээлсэн бол 2-р хорооны нэг ч хэсэгт ийм асуудал гараагүй байна.

Сүүлийн 4 долоо хоногт орлого нь буурсан иргэд (хэсгийн эзлэх хувь)



Багахангай дүүргийн 67 хувьд нь мэдээлэл нэгтгэхээс өмнөх дөрвөн долоо хоногийн хугацаанд орлогын бууралт бүртгэгдээгүй байна. Харин хэсгүүдийн 17 хувьд нь сүүлийн дөрвөн долоо хоногт хэсгийн нийт хүн амын 50 хувь хүртэлх хувьд бүх орлогоо алдсан гэж мэдээлэлсэн нь 873 хүн амыг хамарсан байна. Хэсгүүдийн 83 хувьд нь мэдээлэл цуглуулахаас өмнөх дөрвөн долоо хоногийн хугацаанд бараг хэн ч (0%) бүх орлогоо алдсан гэж мэдээлжээ. Гэсэн хэдий ч хэсгүүдийн 17 хувь нь хүн амын 50 орчим хувь нь бүх орлогоо алдсан гэж мэдээлсэн бөгөөд энэ нь 873 хүнийг хамарсан байна.

Хүнсний аюулгүй байдал (хэсгийн эзлэх хувь)


### Хүнсний хэрэглээ хангалтгүй байгаад санаа зовних



### Хүнсний хэрэглээгээ багасгасан




Сүүлийн 4 долоо хоногт бүх орлогоо алдсан иргэд (хэсгийн эзлэх хувь)



## 1.6 Тулгамдаж буй асуудал болон аюулгүй байдал

Багахангай дүүргийн хэмжээнд хамгийн тулгамдсан асуудал бол санхүү, эдийн засгийн хүнд нөхцөл байдал байв. Хамгийн гол тулгамдаж буй бэрхшээл нь ажилгүйдэл буюу хөдөлмөр эрхлэх боломж бололцоо (хэсгүүдийн 83%-д мэдээлсэн) бөгөөд орлого хангалтгүй (17%) гэж мэдээлжээ. Асуулгад багтсан бусад төрлийн бэрхшээлийн төрлүүдээс дурдагдаагүй байна. Багахангай дүүргийн 2-р хороонд хөдөлмөр эрхлээгүй хүн амаас шалтгаалсан асуудал хамгийн их тулгардаг бөгөөд энэ нь бүх хэсэгт бүртгэгдсэн байна.

Тулгамдаж буй асуудлууд (хэсгийн эзлэх хувь)



Ерөнхий үйлчилгээний хүртээмжгүй байдал (ус, цахилгаан, эрүүл мэнд, боловсрол)

Багахангай дүүргийн хэмжээнд иргэдийн амьжиргаа (ажлын байр) орлогын эх үүсвэр бий болгох боломж дутмаг (67%), эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж муу (33%) гэж бүртгэгдсэн байна. 2-р хорооны бүх хэсэгт амьжиргааны эх үүсвэртэй болох асуудал нэн тэргүүнд анхаарал хандуулах асуудал байсан бол 1-р хорооны хэсгийн 67 хувь нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах шаардлагатай байгаа нь нэн тэргүүнд анхаарал хандуулах асуудал гэж бүртгэгдсэн байна.


Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгарч буй гол бэрхшээл нь гудамж, цэцэрлэгт хүрээлэн, барилга байгууламжид аюулгүй нэвтрэх дэд бүтэц дутмаг (50%) болон тусгай зориулалтын эмнэлгийн тусламж үйлчилгээ дутмаг (50%) байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгамдаж буй асуудал (хэсгийн эзлэх хувь) **50%**




Аюулгүй байдал, (хэсгийн эзлэх хувь)


Оноо: 1= маш муу, 2= муу, 3= дундаж, 4= сайн, 5= маш сайн



Хүндрэлтэй байдаг үйлчилгээ (хэсгийн эзлэх хувь)




Аюулгүй байдлыг хөндсөн асуудал гарсан эсэх (хэсгийн эзлэх хувь)




## 1.7 Дэд бүтэц, үйлчилгээ

### УС

Усны хэрэглээгүй байгаа хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Устай холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




### ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ

Цахилгааны хэрэглээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Цахилгааны хэрэглээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




### ХООЛ ХҮНС

Хүнсний бүтээгдэхүүн хүрэлцээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Хүнсгүй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




### ОРОН БАЙР

Орон байрны хүрэлцээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Орон байртай холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




## ХҮНСНИЙ БУС ЗҮЙЛС

Хүнсний бус бүтээгдэхүүн хүрэлцээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Хүнсний бус бүтээгдэхүүнтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




## ИНТЕРНЭТ

Интернэтэд холбогдоогүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Интернэтийн хэрэглээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




## ЭРҮҮЛ МЭНД

Эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




## УХААЛАГ УТАС

Ухаалаг утас ашигладаггүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)



Ухаалаг утасны хэрэглээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)







## 1.8 Ногоон байгууламж

Мэдээлэл нэгтгэгчээс өөрийн хэсгийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанарт нэгээс тав хүртэл, нэг нь маш муу, тав нь маш сайн гэсэн үнэлгээ өгөхийг хүссэн. Нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар Багахангай дүүргийн хэмжээнд 3.2; айл өрхийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар 2.7; хувийн хэвшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанарыг 3.0 гэж үнэлэв.



Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар  
(хэсгийн эзлэх хувь)

Оноо: 1= маш муу, 2= муу, 3= дундаж, 4= сайн, 5= маш



Өрхийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар



Хувийн хэвшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар




Нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар




## 1.9 Зам тээвэр ба хөдөлгөөн


Хувийн тээврийн хэрэгсэлгүй өрх (хэсгийн эзлэх хувь)



Тээврийн үндсэн аргууд (хэсгийн эзлэх хувь)



Замын хөдөлгөөнтэй холбоотой үндсэн асуудлууд (хэсгийн эзлэх хувь)



Багахангай дүүрэгт замын хөдөлгөөний гол бэрхшээлүүд нь эвдэрсэн зам (хэсгүүдийн 50 хувьд мэдээлсэн), хүүхдүүд тоглох нийтийн талбай байхгүй (17%), замын тэмдэг тэмдэглэгээ болон/эсвэл замын гэрэлтүүлэг дутмаг (17%) байна. 2-р хороонд (хэсгийн 66.7%) хамгийн тулгамдсан асуудал бол эвдэрсэн зам байв. Харьцуулбал 1-р хороонд замын тэмдэг, замын гэрэлтүүлэг дутмаг байв.





© Y.Одбаяр

Уг тайлангийн үр дүн, дүгнэлт нь зөвхөн судалгааны багийн байр суурийг илэрхийлэх бөгөөд ОУШХБ, түүний гишүүн улсууд, Швейцарын хөгжлийн агентлаг болон бусад хандивлагчдын байр суурийг илэрхийлэхгүй болно. Тайлангийн туршид ашигласан тэмдэглэгээ болон материалын танилцуулга нь аливаа улс орон, нутаг дэвсгэр, хот, бүс нутгийн эрх зүйн байдлын талаар ОУШХБ-ын зүгээс ямар нэгэн үзэл бодлоо илэрхийлэх, эсхүл түүний эрх баригчид, хил хязгаарыг илэрхийлээгүй болно.

ОУШХБ нь шилжин суурьшигчид, хөдөлгөөнт хүн ам болон нийгэмд тустай, хүмүүнлэг, аюулгүй, цэгцтэй шилжилт хөдөлгөөний зарчмыг баримтлан ажилладаг. ОУШХБ нь засгийн газар хоорондын байгууллага, олон улсын хамтын нийгэмлэгийн түншүүдтэйгээ дараах зорилтын хүрээнд хамтран ажилладаг. Үүнд: Шилжилт хөдөлгөөний үйл явц дахь сорилтыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх; шилжилт хөдөлгөөний асуудлын талаар мэдлэг мэдээллээ дээшлүүлэх; шилжилт хөдөлгөөнөөр дамжуулан нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих; мөн шилжин суурьшигчдын нэр төр, сайн сайхныг дээдлэх зэрэг болно.


Энэхүү тайлан нь Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэйгээр, ОУШХБ-аас хэрэгжүүлж буй “Монгол Улс дахь дотоод шилжилт хөдөлгөөнийг ойлгож, удирдах нь” төслийн хүрээнд хийгдэж буй ажлуудаас гаргаж буй үр дүнгийн нэг хэсэг юм. Энэхүү төслийн зорилго нь Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицыг (ДТМ) ашиглан Монгол Улсын дотоод шилжилт хөдөлгөөн, хөгжлийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх замаар нотолгоонд суурилсан томъёолол, хэрэгжилтийг бэхжүүлэн бататгахад оршино. Судалгааны аргачлал, арга зүй, дүн шинжилгээ, тайланг загварчлах ажлыг ОУШХБ-ын ДТМ хариуцсан ОУ-ын зөвлөх Витторио Бруни, дотоодын зөвлөх Ганбатын Гэрэлтогтох, туслах ажилтан Болор-эрдэний Маналцогзолын хамт боловсруулсан болно. Судалгааны асуулгыг ОУШХБ-ын баг, НЗДТГ-ын оролцоотойгоор боловсруулсан байна. Судалгааны мэдээллийг ОУШХБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн алба болон Глобал ДТМ-ийг дэмжих багийн удирдлагуудын техникийн дэмжлэгтэйгээр Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицын (ДТМ) хэрэглүүрийг ашиглан цуглуулж, дүн шинжилгээ хийсэн болно.

### 1.10 Хүүхэд ба боловсрол

Багахангай дүүргийн хэмжээнд 0-5 насны 78 хүүхэд цэцэрлэгт хамрагдаагүй (тухайн насны хүн амын 15%), 6-17 насны 10 хүүхэд (тухайн насны хүн амын 1%) цэцэрлэгт хамрагдаагүй байна. Энэ дүүрэгт боловсролд хамрагдаагүй хээхдийн түвшин хотын дунджаас бага буюу 0-5 насны хүүхдүүдийн хувьд 15 пунктээр, 6-17 насныхны хувьд 2 хувиар бага байна. 0-5 насны боловсролд хамрагдаагүй бүх хүүхдүүд 1-р хороонд бүртгэгдсэн бол 6-17 насны боловсролд хамрагдаагүй хүүхдүүд бүгд 2-р хороонд бүртгэгдсэн байна.

Хүүхдүүдийн ерөнхий нөхцөл байдлыг илүү өргөн хүрээнд судлахын тулд мэдээлэл нэгтгэгчээс хүүхдүүдэд тулгардаг үндсэн асуудал өөрсдийн хэсгийн нутаг дэвсгэр дээр хэр байгаа талаар асуусан. Багахангайн хэсгүүдэд 50 хувь нь боловсрол дээр ямар ч асуудал байхгүй гэж хариулсан бол үлдсэн 50 хувь нь сургуулийн чанар муу байна гэж хариулсан байна. Хэсгүүдийн 67 хувьд хүүхдийн клуб, спортын төв байхгүй нь тулгамдсан асуудал байв, 33 хувь нь сургуулиудын сургалтын чанар муу гэж мэдээлсэн болно.

Боловсролтой холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)



Сургуульд хамрагдаагүй хүүхдүүд (хэсгийн эзлэх хувь)

#### 0-5 насны цэцэрлэгт хамрагдаагүй хүүхэд



#### 6-17 насны сургуульд хамрагдаагүй хүүхэд



Хүүхдэд тулгамдаж буй үндсэн асуудлууд (хэсгийн эзлэх хувь)

